

НИЙТЛЭЛ

Тэсрэлт: «Европын Ким Чен Ун» гэгдэх Беларусь Батька***Дашдоржийн Баярхүү**

Гадаад бодлогын эксперт, судлаач – профессор,

Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд

bayardevi@hotmail.com; <https://orcid.org/0000-0002-8297-3572>

Хураангуй: «Дорнод түншилэл» гэх Европын Холбооны санаачилгад Азербайжан, Армен, Беларусь, Гүрж, Молдова, Украиныг татан оролцуулдаг. Беларусь нь 2020 оны «бослого»-д нэрвэгдчихээсээ өмнө энэхүү түншилэлд сэтгэл тэнэгэр явсан. Эдүгээ Армен, Беларусиаас бусад дөрөв нь Оросоосоо бүрэн салж цаашаа харсан, харж байгаа бол, дэглэмээ алдахаас айсан Беларусь нь Орос руугаа 180 градус эргэчихсэн байдалтай. Украины Гадаад хэргийн сайд Дмитрий Кулеба Беларусьт хандан «Русский мир»-ийг (Оросын ертөнц) сөрөн зогсох альтернатив–«Люблины гурвалжин» гэдэгт хөрш орнууд нь нэгдэж нийлье хэмээн уриалсан. Оросыг сөрөөд босоод ирэх, хэрэв тэгж гэмээнэ Беларусьт асар том боломж гараад ирж мэдэх «Дорнод түншилэл», «Люблины гурвалжин»-гаар одоо энэ улс дутахааргүй болжээ. Энэ ямар учир шалтгааны тайлал болохыг дараахи судалгааны өгүүлэлд хөндөн бичлээ. Тэсрэлт гэж гарчигласаны логик утга ч ойлгогдох биз ээ.

Түлхүүр үгс: Беларусийн эцсийн гарц уу?, Лукашенко сүүлчийн нүүдлээ хийлээ, Орост 100 хувь хамааралтай боллоо, Одоо тэр лидер биш.

* Энэхүү бүтээл дэх үнэлэлт дүгнэлт нь зохиогчийн Элчин сайдын болон ГХЯ-д эрхэлж байсан өмнөх алба ажилтай огтоос хамааралгүй, Монгол Улсын албан ёсны байр суурийн тусгал биш гэдгийг анхаарна уу.

Нэг. Нэгэнтээ цайрав. Ухрах гарц байхгүй

Крым бол де-факто Оросын Крым, харин санал асуулгын дараа Крым нь де-юре Оросынх боллоо¹—энэ лут үгс Беларусийн Ерөнхийлөгчийн амнаас цууриатлаа. Хуучин Зөвлөлтийн БНУ-удаас Беларусь ганцаараа Крымыг зөвшөөрлөө. Бусад нь түүнийг дагах нь юу л бол. Украинтай дайсагнаж, тэр хэрээрээ Өрнөдөд булай болохоосоо тэд болгоомжилно.

2021 оны онцлох түүхэн үйл явдал бол Лукашенкогийн Крымыг хүлээн зөвшөөрсөн нь гарцаагүй тэмдэглэгдэж үлдэнэ. Үнэндээ цахиур хагаллаа. Донбасст тэсрэлт гарч, тэд (ДНР, ЛНР гэх хоёр БНУ) тусгаар тогтнолоо ОХУ-аар хүлээн зөвшөөрүүлчихбэл Батька шууд дагахаас аргагүйд хүрнэ.

Ер нь Беларусь нь дэлхий дахины анхаарлын төвд байсаар удаж буй. 2020 оны зун намар тус улсын энэ Ерөнхийлөгч туйлын хүндхэн хэдэн сарыг туулсан. Ард нь Орос алхам бүрийг нь ажиглан зүрхээ базлуулан суусан байх. Холбооны Улс нь нурж унахаас гадна Оростой шууд залгаа, баруун жигүүрт нь бас нэг Евроинтеграцын улс гараад ирнэ гэдэг Оросын эрх баригчдын хувьд даан ч хүлээж авшгүй. СНГ, ЕАЭС, ОДКБ, ШХАБ гээд Оросын бодит ашиг сонирхлын орон зайд туйлын халгаатай байж мэдэх үйл явц Беларусийг, Минскийг 2020 онд бүчин авсан нь тэр билээ.

Оросын хувьд Лукашенко яагаад хэрэгтэй юм бэ гэдэгт оновчтой хариулт өгснөөс ганцыг эшлэе. CIS-ЕМО гэх олон улсын мониторингийн байгууллагын захирал доктор

Станислав Бышок² Америкийн хэвлэлд ийнхүү ярьжээ:

- Оросын зарчмын байр суурь бол хамгийн эмзэг баруун хил дээр нь цорын ганц холбоотноороо энэ улс мөнхөд оршин байх. Тийм учраас юун НАТО-гийн гишүүн, юун НАТО-д элсэх кандидат, тэр ч бүү хэл НАТО-гийн найз ч байж болохгүй. Европын Холбоог сонгох зам ч байж болохгүй.
- Беларусьг Ерөнхийлөгчийн сонгууль болдог юм аа гэхэд Өрнөдийн ардчилалтай харилцаагаа хэвийн болгох үзэл бодол бүхий кандидатыг ялуулж огт болохгүй. Хэрэв энэ дээр алдаа л бол, бүх беларусьчууд Өрнөдтэй иргэншлийн зам сонгохоор эргэчихнэ, энэ бол Оросын хувьд хамгийн чухал чиглэлдээ цорын ганц холбоотноо алдлаа гэсэн үг хэмээн Кремльд хөдлөшгүй үздэг.
- Аюулгүй байдал нэгдүгээрт тавигдаж байгаа учраас түүндээ эдийн засаг, Дорнод Славяны романтик сэтгэлээ захируулчихна.

Орос эрдэмтэн С.Бышок баараггүй үнэн хэлжээ. ОХУ-ын зарчмын байр суурь яг мөн. Энэ байр сууриа дараа дараалан алдаад одоо боож үхэхэд тун ойрхон яваа их айл. Одоо Беларусийг л эргэлтгүй тогтоож авахгүй бол оройтно. Тиймдээ ч хоёр талын харилцаанаас гадна олон талт хамтын ажиллагааны механизмуудыг түлхүү ашиглана.

¹ Александр Лукашенко: Мы все понимали, что Крым де-факто это российский Крым. После референдума и де-юре Крым стал российским, *forbes.ru/society/30.10.2021*

² Isolation Pushes Belarus's Lukashenko Closer to Russia's Putin, *The Wall Street Journal*, May 28, 2021

ШХАБ-ын саммитад В.Путины өөрийнх нь хэлсэн үг³ байна. Юу гэвэл ОХУ-ын нутаг дэвсгэрт, Оренбург мужид явагдах ШХАБ-ын «Мирная миссия–2021» хамтарсан цэргийн ээлжит хээрийн сургуульд ШХАБ-ын бусад гишүүн улсуудтайгаа харилцан тохиролцоод Бүгд Найрамдах Беларусь Улсыг татан оруулахаар боллоо гэжээ.

Беларусь нь ШХАБ-д харилцан ажиллагаа хөгжүүлэхдээ антитеррорист бүтцийн шугамаар цэргийн салбарт хамтын ажиллагаа өрнүүлэх болно⁴ гэдгээ ч илээр зарласан. ШХАБ-ын саммитад уригдан очсон Александр Лукашенко энэ байгууллагын 20 жилийн ойд зориулсан дээд хэмжээний уулзалтад үг хэлэхдээ, “Орчин үеийн

глобал хурц аюулаас үүдсэн түүхэн стресс-тест манай байгууллагын бүхий л 20 жилийн түүхнээ тохиогоогүй, харин одоо тулгарлаа⁵” гэсэн нь маш ноцтой анхааруулга, дүгнэлт гэж ойлгогдож байна. Өмнөх өдөр нь ОДКБ-гийн саммитад үг хэлэхдээ, “Евразийн тивд аюулгүй байдлын гарант, донор болохын төлөө зогсож буй ОДКБ-г хөгжүүлэх талаар шинэ урт хугацааны зорилтуудаа тодорхойлцгоо⁶” гэжээ.

2020 оны зун-намрынх шиг аймшигтай үйл явдал Беларусийг нөмрөөд авна, дэглэм суларна, бүр унах аюултай, тэр нь ШХАБ, ОДКБ хоёрт том аюул болж магадгүй шүү гэсэн анхааруулга л яваад байх бололтой.

Хоёр. Европоос бүрэн таслагдав

Лукашенког 2020 оны намраас хууль бус Ерөнхийлөгч хэмээн Европын Холбоо, АНУ үздэг болсон, тэрээр засгийн эрхэнд зууралдан үлдсэн, дэнжигнэж байгаа, одоо бол ердөө л оросын тал баримтлагч, тэр нэрээрээ л тогтож байгаа хэмээн Өрнөдөд үзэгдэн буй. Тэгэхдээ эх орныхоо бүрэн эрхт байдлыг алдчихгүйн тулд олон талын тоглолт хийж байгаа нь Оросоос гадна ШХАБ, ОДКБ-д итгэл үзүүлж байгаагаас нь харагдана. Эх орных нь бүрэн эрхт байдал хамгийн чухал нь биш, энэ удаа өөрийнх нь дэглэмийн бүрэн эрхт байдал тэргүүнд тавигдаж байж шиг.

Беларусийн «босогчид»-ыг ч АНУ, Өрнөд ил тодоор дэмжиж байсан, дахин идэвхжээд

босоод ирвэл бүр ч ил тод дэмжих биз. АНУ-ын Конгресс дэх украины лобби тус улс дахь ардчилал хүний эрхийг хамгаалах асуудлыг Байдены тэргүүлэх бодлого болготол тэмцсэн. Беларусь ба Украиныг Европын ирээдүйн интеграцын бүтэц рүү оруулахад туслах нь тэрхүү лобби бүлгийн үндсэн гол зорилго болох аж. Конгрессын Төлөөлөгчдийн Тамхимын гишүүн хатагтай Марси Каптур⁷ энэ талаар гаргууд ажиллаж байв. «Төв болон Дорнод Европын Коалиц» (Central and Eastern Europe Coalition буюу товчилбол СЕЕС) гэгчийг санаачлан Беларусийг диктатураас ардчилал руу шилжүүлэх асуудлаар видео-конференц гэгчийг зохион байгуулжээ. Түүнд тэрээр илтгэл

³ Совместное заседание глав государств – членов ШОС и ОДКБ, *kremlin.ru*, 17 сентября 2021 года

⁴ Лукашенко принимает участие в саммите ШОС. Какие интересы у Беларуси в этой организации? *belarus.by*, 17 сентября 2021 г.

⁵ Лукашенко: наступает время исторического стресс-теста для ШОС, мөн тэр сайтын мэдээ

⁶ Лукашенко: ОДКБ выступает гарантом и донором безопасности на Евразийском континенте, *belarus.by*, 16 сентября 2021 г.

⁷ Belarus Focus of Central and East European Coalition Policy Discussion, *eancdc.wordpress.com*, March 5 2021

тавихдаа Трансатлантын холбоотны харилцаанд чухал үүрэгтэй алхам бол Европын Холбоонд Беларусь, Украиныг нэгтгэх явдал хэмээн шууд хэлэв. Тэрээр Конгресс дэх Украины кокус гэдгийг толгойлохдоо посткоммунист Европын асуудлаар дагнан ажиллаж ирсэн, «Беларусь дахь ардчиллын тухай хууль»⁸ Конгресст батлуулахад голлох үүрэгтэй оролцсон, Беларусийн иргэний нийгмийг бүх талаар дэмжсэн, Эрх чөлөө радиостанцын беларусь хэл дээрхи нэвтрүүлгийг нь дэмждэг гээд бичвэл олон баримт сөхөж болно. Жо Байдены Засгийн газарт Беларусь хариуцсан тусгай төлөөлөгч томилуулна гэсэн нь хэрэгжээгүй байх шиг байна.

Лукашенког 2020 оны намраас хууль бус Ерөнхийлөгч хэмээн Европын Холбоо, АНУ үздэг болсныг дагалдаад Беларусийн сөрөг хүчний лидер Светлана Тихановская гэх бүсгүй Өрнөдөд дээшээ өгсөөд нэр нь цууриатсан. Беларусийн асуудлаар НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлд хэлэлцүүлэг⁹ өрнүүлэхээр түүний санаачилсныг Эстони, Норвег дэмжсэн. Энэ талаар «Умардын орнууд»-тай хэрхэн ажиллаж байсан баримт байна. Онлайн уулзалтуудыг угсраагаар хийжээ. Норвег, Швед, Финланд, Дани, Исланд, Нидерланд, Эстони, Латви, Канад гэхчлэн. 2021 онд Эстони, Норвег хоёр Аюулгүйн Зөвлөлийн гишүүн байсныг ашиглаад авъя гэж уухайлжээ. Беларусьт хүчирхийлэл шатлан өргөжлөө, хямралыг энхийг аргаар шийдвэрлэхүй гэсэн сэдвээр сонсгол тавихаар болж байв. Энэ нь бүтээгүй.

Минсктэй яриа хэлэлцээ хийх үндсэн талбар нь ЕАБХАБ (Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага) байх тухай Шведийн санаачилга нэг хэсэг яригдаад бас чимээгүй болсон.

Лукашенкогийн дэглэмийн хоногийн тоо ойртож байгааг илтгэх өөр олон баримтууд байна. «Та бүхэн хэнтэй интеграцчилагдахыг илүүд үздэг вэ?» гэх асуултад хоёр л хариулт зонхилно. Нэг бол Оростой, нэг бол Европтой. Гэтэл тус улсын 30-35 насны залуусын 70 орчим хувь нь Европын Холбоотой гэх хариулт өгсөн байх аж¹⁰. Улс төрийн газар зүй, орчин үеийн геополитик судалдаг орос эрдэмтэн Андрей Скриба ийм баримт эшлэжээ. «Оросоос Беларусийн ялгагдах гол шинж нь энэ 70 хувь мөн» хэмээн орос эрдэмтэн үзжээ. Яг одоо беларусьчууд өөрсдийн онцлог төрхөө олж тогтоох эрлийн замд яваа, одоо тэд үлэмж идэвхтэй болсон, бусад ард түмнээс ялгарах тэр онцлог-дангааршлаа олж авахын тулд дотооддоо эв нэгдэлтэй байна. Харин эрх баригчид нь арагшаа нэг ухарчихсан, хуучин загвараар явахыг хичээдэг, нийгэм нь хүлээж авахгүй, тийм нөхцөл бүрдчихсэн. 2020 оны сонгууль бол пост-зөвлөлт улсуудад түгээмэл харагддаг стресс-тест, тогтолцоонд итгэж байна уу гэдгийг шалгах референдум болж өнгөрсөн. Хуучин зөвлөлтийн механизмаар яваад байж болохгүй, Хойд Солонгос шиг гадаад ертөнцөөс бүрэн таслагдах уу, эсвэл мэдээлжсэн ажлын технологи эзэмших үү гэдэгт беларусьчууд өөрөөр хардаг, олон улсын системд Беларусийн

⁸ H.R.8438 - Belarus Democracy, Human Rights, and Sovereignty Act of 2020 116th Congress (2019-2020), [congress.gov](https://www.congress.gov)

⁹ Тихановская призвала инициировать в Совбезе ООН слушания по Белоруссии, russian.rt.com/news/2021/04/08/

¹⁰ «Молодежь нацелена в Европу» Белорусы вслед за украинцами стремятся в ЕС. Как Россия может их удержать? yandex.ua/news/25 октября 2021

нийгмийг оруулахын төлөө зүтгэх болно. хандарч байгаа нь яалт ч үгүй үнэн гэхчлэн
Беларусийн залуучууд Европын Холбоо руу Скриба ярьсан байх аж.

Гурав. «Өмнөд фронтын шугам»

Олон талаасаа боорлуулсан Лукашенко Оросоос өөр ар тал, гарц үлдсэнгүй. 2014 оны Майданы хувьсгалын дараа Украинтай найрсаг харилцаагаа хөгжүүлээд, оросуудынхаа зэвүүцлийг төрүүлж явсан Лукашенко гэв гэнэт «Өмнөд фронтын шугам»-ын тухай яриад эхлэв. 2020 оны зун-намрын бослого тэмцлийг Өрнөдийн тал баримтлагч Киев эргэлтгүй дэмжсэнийг ийнхүү өмнөдөөс ирэх тэсрэх бөмбөг сум хэмээн ойлгожээ. Баранович дахь цэргийн полигон Лукашенкогийн байнга очдог газар боллоо. Баруун хилээ Оросын зенит-пуужингийн С-300 гэх комплекс зэвсгээр халхалж авснаа одоо Украины зүгээс өдөөгдөх цэргийн аюулд Беларусь бэлэн байх тухай ярьдаг болж, Беларусь-Украины хил дээр Оросын С-400 пуужин зоож эхлэв. 2025 он хүртэл Беларусийн армийг шинэчлэн зэвсэглэх Оросын зэвсгийн жагсаалтыг Беларусь, Оросын Ерөнхийлөгч нар тохиролцсон ба Оросоос тэрбум доллар зээлж аваад Оросын зэвсгийг Оросоос нь худалдан авах тухай ярьжээ¹¹.

Хэрэв Беларусь руу халдан довтолбол юу болж дуусахыг тэрээр CNN сувгаар ширүүхэн лүндэгдэж байв. Москватай л Минск илүү ойртоход хүргэнэ дээ. Хэрэв хэрэгтэй гэж үзвэл Беларусь ба Оросын нэгдсэн бааз болж хувирна. Та нарын түрэмгийллийг сөрөн зогсохын тулд Оростой хамтран хамтарсан хариуг өгөх болно. Хэрэв Беларусь руу халдан довтолно гэж бодож

байгаа бол тэдгээр орнууд үүнийг хатуу ойлгож авбал зохино¹².

Ийнхүү өвч бүрэн зэвсэглэсэн Лукашенко ингэхэд хэний аманд гүйж оров оо гэдэгт тус улсын өөрийнх нь иргэд, улс төрчид шүүмжлэнгүй хандаж байгаа ганц жишээг эшлэе. “Бодит тусгаар тогтнол манай улсад алга, тусгаар тогтнолоо алдсаны буруутан нь Лукашенко, бид Оросоос бүрэн хараат болсныг мэдрэхийн дээдээр мэдрч байна. Манай Ерөнхийлөгч аман дээрээ өөрийг ярих боловч Оросын хүссэнийг л хийдэг хүн” хэмээн тус улсын Дээд Зөвлөлийн дарга асан Станислав Шушкевич тэмдэглэн хэлжээ¹³. Ардчиллын зарчим Украин, Молдав, Балтийн орнуудаас бусад хуучин СССР-ийн бүх БНУ-д алдагдсан, зөрчигдсэн, одоогийн Беларусийн Ерөнхийлөгчийн өнгөн дээр манай улс Зөвлөлт Холбоот Улсын үед байснаасаа дордсон, одоо тус орны засгийн эрхийг «КГБ-гийнхны олигархи хунт» аваад байна гэхчлэн эрс хатуу шүүмжилжээ.

Одоогоор өвч бүрэн зэвсэглэхээд, ОХУ, ОДКБ, ШХАБ-аар бамбай хийчихээд буй Лукашенко сөрөг хүчин нь ямагтын аюул байх болов уу, үгүй юү? Ямар ч гэсэн «их дайны өмнөх нам гүм» гэсэн сэтгэхүйгээр нийгмээ айлгаад авлаа. Сөрөг хүчний ихэнхи удирдагчид нь арга буюу гадаадад дүрвээд гарчихсан, нутагтаа байгаа нь Мария Колесниковагаас

¹¹ Беларусь планирует закупку российского вооружения более чем на \$1 млрд, belta.by/president/12 Сентября 2021

¹² Belarus President Alexander Lukashenko derides reports of abuse as 'fake and fantasy', edition.cnn.com, 2021/09/30/

¹³ Шушкевич заявил, что за 30 лет Белоруссия потеряла независимость, gazeta.ru/politics/2021/08/25

эхлээд бүгд шоронд, бие даасан сэтгүүлчид, СМИ нь үйл ажиллагаагаа зогсоосон, мөн олон сэтгүүлч эх орноосоо хөөгдсөн, эх орондоо үлдсэн нь бас торны цаана, тайван жагсаал

цуглааны ул мөр алга болчихсон, ийм л Беларусь Орос ахынхаа өмнө тусгаар тогтносон улс гэхэд хэцүүхэн байж байна

Дөрөв. Миграц гэж шинэ зэвсэг, шинэ тэсрэлт

Олон улсын харилцаа 2021 онд «цагаачлалын хямрал-геополитикийн зэвсэг» гэх шинэ агуулгаар баяжсан он болж түүхэнд орлоо. Чухам үүнийг Лукашенко гарамгай хэрэгжүүлж геополитикийн тоглолт болголоо. Эсрэгцсэн хоёр субъектын хилийн зааг дээр миграц хиймлээр үүсгэж нөгөө талаа дарамтлах шинэ тоглолт.

Энэ маань 2021 оны 5 дугаар сард анх нөхцөлджээ. Тэр үед Ruanaig агаарын тээврийн компанийн онгоцыг албадан буулгаж, Беларусийн тусгайнхан сөрөг хүчний блогер Роман Протасевичийг баривчилсны дараахан Беларусь-Өрнөдийн хооронд хэрүүл дэгдэж, Өрнөд рүү зүглэх цагаач дүрвэгсдийн цуваа, хар тамхины зөөвөрт хяналтаа сулруулна шүү хэмээн Лукашенко аман заналхийллээрээ дарамталснаар нөхцөлдсөн хэрэг юм. Энэ нь явсаар явсаар 11 дүгээр сар гэхэд тэсрэлтэд хүргэжээ.

Хөрш Польш үүнд хамгийн анх өртжээ. Польшийн Ерөнхий сайд Матеуш Моравецкий үүнийг яг онож хэлсэн үгс нь байна¹⁴. Хоёр улсын хил дээр цагаачдыг бөөгнүүлэн хямрал дэгдээснээрээ Беларусь нь «төрийн терроризм» хийсэн ялтнаар тодорчээ. Энэ бол Лукашенкогийн «чимээгүй өс авалт» хэмээн яллахаа ч бас мартсангүй. Варшавт хэвлэлийн хурал дээр Европын Зөвлөлийн дарга Шарль

Мишельтэй зэрэгцэж зогсож байгаад тэгж ярьсан ба Европын Холбоо Польшийн бат бэх ар тал болно хэмээн цаад нөхөр нь мэдэгдэж байв. Тэр хоёрын ярьснаар бол Минскийн эрх баригчид Африк, Ойрхи Дорнод, Афганистанаас цагаачдыг хэргээр Беларусьт урьж авчран, Лукашенко тэднийг «зэвсэг» болгон ашиглажээ. Польшийн талын мэдээлснээр 12 мянган цагаач дүрвэгч тус улсын хил давахаар бөөгнөрчээ. Беларусийн эсрэг Өрнөдийн санкцыг Польш дэмжсэнийх нь төлөө Лукашенко өшөө авч байгаа хэлбэр нь энэ хэмээн ноён Моравецкий мэдэгджээ.

Моравецкий, Шарль Мишель нарын ярьснаас улбаалаад Беларусийн Ерөнхийлөгчийн ээлжит тоглолтыг Оросын хийлгэж байгаа зориудын үйлдэл болгон Өрнөдөд дэвэргэсэн¹⁵. Тэр нь Украины хил дагуу Оросын хийж буй дайны бэлтгэлээс дэлхий дахины анхаарлыг холдуулах гэсэн алхам болж шат ахисан. АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Энтони Блинкен Польшийн Гадаад хэргийн сайд Збигнев Раутай ярилцахдаа тэгж мэдэгдсэн ба АНУ-ын Төрийн Департаментын төлөөлөгч Нед Прайс бас тэгж ярьжээ.

Лукашенкогийн дэглэм хамгаалалтгүй нүцгэн цагаачдыг эрээ цээргүй ашиглалаа. Лукашенкогийн дэглэмийн үйлдэл аюулгүй

¹⁴ Poland Accuses Belarus of Terrorism at Border, *voanews.com*, November 10, 2021

¹⁵ U.S., Poland discuss Belarus migrants, Russian aggression – Blinken, *saltwire.com*, Reuters Nov.14, 2021,

байдалд заналхийллээ, гол нь ийм хэрүүл дэгдээснээрээ Украинтай залгаа хил дээрх Оросын үйлдлээс анхаарал сарниулахыг зорилоо. Беларусийн ард түмний хүний эрх, суурь эрх чөлөөнөөс татгалзсан хэрнээ цагаачдын эрх ярин Европыг дарамтлах Беларусь, Оросын үйлдлийг санал нэгтэй буруушааж байна. Украины бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг дэмждэг Польшид АНУ талархлаа гэхчлэн Блинкен, Прайс нар ярьсан байгаа юм.

Польш–Беларусийн хил дээр дүрвэгсдийн хямрал дэгдмэгц Украин олон хувилбараар бэлтгэл хийж эхэлжээ. Тус улсын ҮАББХЗ-ийн нарийн бичгийн дарга Алексей Данилов, Гадаад хэргийн сайд асан Павел Климкин нар дараа дараалан мэдэгдэл хийж Орос руу хамаг ялыг тохов¹⁶. Беларусиаас дүрвэгсдийн давалгаа ороод ирвэл Украин улс Европын Холбооны тусламжинд л найдна, өөр гарц байхгүй гэв. АНУ–Мексикийн хил дээр болж байсан шиг үйл явдал давтагдлаа. Путин Европын Холбоог шантаажиллаа, Байденыг ч өдөөн хатгалаа гэв. Украин, Польш, Литва, Латвийн ҮАБЗ-ийн нарийн бичгийн дарга нарыг Брюссельд цуглуулж хуралдуулах хэрэгтэй, нэгдсэн стратегиа боловсруулах хэрэгтэй хэмээн тэд уриалав.

Матеуш Моравецкий, Шарль Мишель, Энтони Блинкен, Збигнев Рау, Алексей Данилов, Павел Климкин нарын ярьсныг батлан нотлох гэсэн мэт Лукашенко ам түргэдэн Оросыг бариад өгчихөв¹⁷. Беларусийн хил рүү цагаачдыг хүргэж ирсэн нь Оросын иргэд,

тухайлбал чеченьчүүдийг дурдаж тэрээр Оросын сэтгүүлчдэд ярилцлага өгчээ. Хувийн компани, такси, автобусаар тэднийг зөөсөн, Оросын зуучлагчид л ажилласан. Ийм лут зохион байгуулалттай чеченьчүүдэд баярлалаа. Тэд л Минскээс хүмүүсийг хил хүргэхэд туслаж, бас хил давахад нь туслаж магадгүй. Беларусьт байгаа цагаачид Украинтай зэвсгийн контрабанд хийдэг, тэр зэвсгээ Беларусийн лидер, Оросын цэргийн бааз, сэтгүүлчдийн эсрэг ашиглах гэж байгаа гэх мэтээр хальж ярьжээ. Цагаачид Минск, Гродно хавиар шуугиж л байг, шинэ жилээс өмнө шийдчихнэ, нутагтаа харихыг бид тэднэс хүснэ, мянган хүн Ирак руугаа буцчихсан байгаа, Герман руу тэднийг илгээх хүмүүнлэгийн коридор бүтэхгүй юм байна¹⁸ гэхчлэн Лукашенко ярьж байв. Визгүй нэвтэрдэг учраас тэд чартер нислэгээр Беларусь–Польшийн хил дээр очсон гэдгийг ч Оросын Ерөнхийлөгч өөрөө хүлээн зөвшөөрчээ¹⁹. Дүрвэгсдийн зөөвөрлөсөн “Аэрофлот”, Беларусийн “Белавиа” болон Туркийн “Turkish Airways” агаарын компаниуд ял зэмд бас унажээ. Харин Путин “Аэрофлот”-оо ялгүй өнгөрүүлэх гэж ганц нэг ам алдаад чимээгүй болсон.

Лукашенкогийн ам мэхэнд унасан Ирак санкц тавиулах ял зэмтэйгээр энэ хэрэгт холбогджээ. Турк дээр ч ял зэм буухаар болж байх шиг. Багдадаас ч дүрвэгсдээ татаж авна гэх ам өчиг өгчээ. Орос үүнд нь туслахаар болжээ. Цагаачдаар геополитикийн зэвсэг хийн Европыг сөхрүүлэх гэсэн Беларусийн эрх баригчдад

¹⁶ На Украине заявили о «спланированной операции» России и Белоруссии, *imag.one*, 12.11.2021

¹⁷ Президент Лукашенко: среди организаторов доставки мигрантов к границе были и россияне, *ria.ru/2021/12/01/*

¹⁸ Meeting with refugees in logistics hub near Bruzgi checkpoint, *president.gov.by*, November 26, 2021

¹⁹ Путин прокомментировал ситуацию с перевозкой мигрантов в Белоруссии, *lenta.ru/2021/11/13/migrants/*

Европын Холбоо нэмэлт санкц тавихаар ярилцжээ.

Болхидуухан төсөөлвөөс «Арабын хавар»-ын хөлд нэрвэгдсэн, Сири дэх дайнаас дүрвэсэн, Ирак дахь шашны дайнаас залхсан дүрвэгсдэд Германд цагаачлуулах ам өгч, элсүүлж, Орос, Беларусь, Турк, Ирак (магадгүй Сири) хамсан хэдэн мянган цагаачдыг Минск рүү агаараар зөөсөн ба тэднийг баруун хил рүү газраар зөөвөрлөн хил дээр хуаран үүсгэж, боломж гарвал тэд Польш, Прибалтикийн хил давж Европын Холбооны орнуудаар таран цагаачилж, дүрвэгсдийн (магадгүй лалын) давалгаа үүсгэж

Европын Холбоо, НАТО-гийн орнуудыг дотроос нь сулруулах, хэрэв эв нь таарвал бүр нураах, тэгснээрээ Орос, Беларусь хожих, Европын Холбоо, НАТО хохирох, Турк нь сири цагаач дүрвэгсдийн ачаанаасаа бага ч болов хөнгөрөх ёстой байжээ. Олон дахин хориг тавиулсан Орос, Беларусийн хувьд энэ нь чимээгүй өс авалт, харин Европын Холбоонд элсэх шалгуур босгоо өндөрсгөж Р.Т.Эрдоганд хатуу хандаж байгаагийн хувьд мөн Эрдоганы бас нэг чимээгүй өс авалт ч болох байсан юм бил үү?

Тав. Орос заавал холбогдох албатай юу?

Беларусийн улс төр судлаач Павел Усов гэх тэрс үзэлт нөхөр мигрантын асуудлаар сонирхолтой ярилцлага өрнүүлжээ. Ер нь газар зүйн байршлаа дагаад Беларусьт цагаачид цуглараад их бага хэмжээгээр Польшийн хил давдаг, тэгснээрээ Европын Холбооны нутаг дэвсгэрт нэвтэрдэг явдал дээхнээс байсан юм байна. Гэвч мөргөлдөөний голомт болтлоо хурцдаж байгаагүй. Харин энэ удаа Лукашенко цагаачдын транзитад улсаа холбосноор Беларусьт цагаачдыг оруулж ирдэг бүхэн бүтэн эрүүгийн сүлжээ буй болгожээ. Гэтэл түүнд энэ улс, ард түмэн нь бэлтгэгдээгүй байжээ²⁰ хэмээн тэрээр уулга алдан ярьсан байх юм. Түүний ярьсныг бараг тэр чигт хөрвүүлээд Орос энд ямар хамаатай вэ гэдэгт хариулт өгмөөр санагдлаа.

Одоо хол ойрын мигрантууд Чечениэс авахуулаад Ойрхи Дорнодыг бүхэлд нь хамрах дүрвэгсдийн урсгал энэ орныг нөмрөх

магадлалтай. Үүний хариуцлагыг Лукашенко хүлээнэ. Украины эсрэг Орос 2014 онд түрэмгийлэл үйлдэнэ чинээ Өрнөдөд хэн ч төсөөлөөгүй байж байтал гэнэт тийм радикал сценарийг Орос тулгасан шиг яг одоо Лукашенко өрнөдийнхнийг төсөөлөөгүй байж байхад нь дарамтлах зэвсгээ олоод авлаа. Европын Холбоо сул дорой нь ч харагдаж байна. Сул дорой, удаан байх л юм бол авторитар тогтолцоо илүү шуурхай ажилладаг. Европын Холбоонд сэтгэл зүйн дарамт үзүүлэх шинэ шинэ зэвсэг олно, хэрэглэнэ. Беларусийн эрх баригчид хууль бус цагаачдын транзитаас 200 сая ам.доллар олох бодолтой.

Яг энэ үйл явц дээр Орос давхар тоглож байна. Беларусийн хилийн ойролцоо стратегийн бөмбөгдөгч Ту-22 онгоцоо байнга нисгэж, Оросын зэвсэгт хүчнийг байршуулж байна. 2020 оны 8 дугаар сард Лукашенко, Путин нарын байгуулсан нууц гэрээгээр Беларусь дахь

²⁰ BelarusToday is on Facebook: Беларусь ради своего блага должна получить статус союзника США

Оросын цэргийн оролцоог эрс өсгөжээ. Харин Өрнөдөд үүнийг Орос Беларусийг цэргийн хүчээр эзлээд авлаа гэж үзнэ. Орос ямар зохиомжоор ажиллаж байна гэхлээр Польш, Литвагийн хил дээр дүрвэгсдээр өдөөн хатгалга үйлдүүлж мөргөлдөөнийг шат ахиулаад, цаад хоёр улс нь хаалт хашлага босгож цэрэг бөөгнүүлээд, тэрийг нь НАТО дэмжээд, тэгэхлээр нь Холбооны улсад нь цэргийн аюул учруулаа хэмээн Москвад үзэх аж. Харьцуулбаас дэлхийн II дайны өмнө Зөвлөлт Холбоот Улс Балтийн улсуудыг эзлэн авсан тэр үйл явц л давтагдаж байна. Беларусийн баруун хил дээрх дүрвэгсэд цагаачдын хямралыг Путинтэй ярилцаж шийдвэрлэхээр Меркель гэх мэт Европын улс төрчид утасдаж холбоо барьж байгаа нь гарцаагүй энэ бүх операцын «мозговой центр»-тэй ярилцах гэсэн санаа байсан хэрэг. Бүх юмны цаана Путин байна. Европын нэг дутагдал бол Лукашенко Путины холбоотон гэдгийг тэр бүр ойлгодоггүй гачлан байна. Лукашенко бол Путины гадаад бодлогын зэвсэг, Европ руу дарамт шахалт үзүүлэх зэвсэг. Путинд геополитикийн маш тодорхой зорилго, ашиг сонирхол байна. Тэр нь Беларусийн талаар

Европ зөвхөн Кремльтэй яриа хэлэлцээ хийхээс аргагүй байдалд Европыг шахаж оруулах явдал.

Орос бол «Европын клуб»-тээ эргэж орох, тэгэх тэгэхдээ хүнд хэцүү нөхцөлд Европыг аврагчийн дүрээр том тоглогч болж орж ирэх төлөвлөгөөтэй. «Нормандын дөрвөл» гэх хэлэлцээний формат бол Москвагаас Европт нөлөөгөө бэхжүүлэх нэг хэрэгсэл нь. Эцсийн зорилго нь Оросын эсрэг тавьсан бүх хоригийг цуцлуулах. Крымын аннекс, Украины эсрэг түрэмгийллээ бүгдийг хүлээн зөвшөөрүүлж байж шүү дээ. Путин, Лукашенко нарын өнгөн дээр авторитар энэ хоёр улстай харилцан ойлголцоно гэж нэн түвэгтэй, бараг бүтэхгүй. Лукашенко руу хэрхэн хандана Холбооны Улс руу нь хандаж байна гэсэн үг. Оросын хувьд Беларусийн улс төрийн дэглэмийг тогтвортой, баталгаатай хангаад байх асар их нөөц бүхий потенциал бий. Тэгэхлээр АНУ-аас том дэмжлэг авч байж Европын Холбоо Оросын эсрэг маш том санкц тавибал энэ хямралыг зохицуулах гарц харагдаж магадгүй. Дэлхийн хамтын нийгэмлэг, ДЭМБ, Улаан загалмай бүгдээрээ Беларусь дахь цагаачдын хямралыг хамтран шийдвэрлэх хэрэгтэй хэмээн ноён Павел Усов ярьжээ.

Зургаа. «Яг л Ким Чен Ун»

Гарчигт нэрлэсэн үйлдлийг Лукашенко хийсэн учраас Оросын өөрийнх нь эрдэмтэд, СМИ тэгж хоч нэр хайрлажээ. Мусульман цагаачдаар Европын хил дээр мөргөлдөөн сэдэхийн сацуу «Ямал–Европа» гэх байгалийн хийн нийлүүлэлтийг завсраас нь хааж Европыг

барьц алдуулна гэсэн нь АНУ руу цөмийн пуужингаар цохилт өгнө хэмээн ам шүд алддаг Хойд Солонгосын Ким Чен Унтай яг адилхан байна²¹ хэмээн Оросын эдийн засагч эрдэмтэн Алексей Коренев харьцуулаад ярьчихсан байх жишээтэй. Лукашенко нь чанга дуугаар, өдөөн

²¹ Экономист Коренев сравнил угрозы Лукашенко перекрыть газопровод с политикой Ким Чен Ына, actualnews.org/exclusive/ 11 ноября 2021

хатгасан, шуугиан дэгдээсэн мэдэгдэл байнга хийдэг ба харин түүнээсээ дараа нь татгалзчихдаг гэмтэй. Эрчим хүчний хямрал тохиож байна, яг энэ үед нь Европын лидерүүдийг цочтол нь, жирийн европчуудыг айтал нь “Гаазыг чинь хаалаа” гээд хэлээд тавьчихад Лукашенко хотойхгүй. Хамгийн хөндүүр цэгийг нь олоод хатгаж байгаатай адил. Үнэхээр хийн хоолойгоо хаалгачихдаг, Европт хий очдоггүй, өвөл болж байдаг, хөөрхөн шантааж болно, өнгөцхөн төсөөлбөл. Беларусь нь Европтой худалдаа хийхгүй байж болно, чадна, худалдааны гол түнш нь Орос учраас энэ улс вакуумд орно гэж байхгүй.

Лукашенко-той адил тэгнэ ингэнэ гэдэг мэдэгдэл Ким Чен Ун байнга хийдэг. АНУ-ын нутаг дэвсгэрт пуужингийн цохилт хэдэн ч удаа хийчих шахав даа. Гэвч тийшээ ганц ч пуужин хөөргөөгүй, хүч тэнцвэргүй тулаанд амиа хорлох гээгүй л юм бол хэзээ ч тэгэхгүйгээ мэднэ. Тэгж тэгж Өмнөд Солонгосоор дамжуулаад АНУ ба Өрнөдөөс тусламж авчихдаг. Явж явж хамгийн их тусалсан нь заналт дайсан Америк нь болж таарсан.

Ким Чен Уны энэ өвчинг одоо Лукашенко тусчихаад байдаг, хэрэг дээрээ хэзээ ч тэр гааз нэвтрүүлэлтийг хааж чадахгүй. Беларусьт нөхцөл байдал тун хүнд байна. Олон мянган өлөн зэлмүүн дүрвэгсдийг хааш нь хийхэв, Европ авахгүй, өөртөө үлдээе бөөн гай, энэ тал дээр Герман ч, Орос ч тус улсад туслах хүсэл алга. Тэгэхлээр нь дүрвэгсдийг нэвтрүүлэхгүй бол, тодорхой хэлбэл Польш хилээ нээхгүй бол байгалийн хийг чинь дамжуулахгүй гэхээс өөрөөр яах билээ. Харин гааз тасалдуулбал

Герман, Франц, Польш, Европын бусад улсууд нийлж байгаад Беларусийг хатуу шийтгэхч гээд байдаг.

ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путин энэ асуудлаар Лукашенкод дэмжлэг үзүүлээгүй, түүнтэй ярилцаагүй, энэ тухай анх удаа сонсож байна, Лукашенко-той хоёр удаа уулзсан, энэ тухай юу ч хэлээгүй, цухуйлгаа ч үгүй²² хэмээн няцаажээ. Лукашенкогийн сул амнаас болж Орос нь гаазын экспортоосоо салахыг хүсэхгүй нь мэдээж. Лукашенко Москватай огт тохиролцоогүйгээр ийм мэдэгдэл хийлээ гэдгийг Кремлийн хэвлэлийн төлөөлөгч Дмитрий Песков бас яаран мэдэгджээ.

Оросын нефть-хийн үйлдвэрлэгчдийн холбоо гэх байгууллага Беларусийн лидерийн заналхийлэлд шүүмжлэлтэй ханджээ. Оросын хувьд нэн аюултай, хэрэв тэгж зогсоох дээрээ тулах юм бол Европын худалдан авагчдын өмнө Оросын нэр хүнд, амлалт унана. Холбооны дарга Геннадий Шмаль хэлжээ:–хий Оросоос явж байна, Беларусийн хэсэг нь “Газпром”-д харьяалагддаг, транзит зогсоох тухай ямар ч яриа өрнөөгүй, өрнөх ч ёсгүй, харин ч Лукашенкогийн энэ сүрдүүлэг европчуудыг цааш нь түлхэнэ, тэд өөр өөрөөр дүгнэнэ, гааз нийлүүлэгч нь улс төрийн зорилгор экспорт хийдэг юм байна гэж ойлгоно, ингэж хэлүүлэх нь бидэнд багадлаа гэж үү, Лукашенкогийн мэдэгдэл буруу, түүнийг хэн ч дэмжиж болохгүй гэв²³. Үндэсний эрчим хүчний аюулгүй байдлын фондоос ч Геннадий Шмалийн хэлснийг дэмжжээ. Лукашенког “Газпром” дураар нь дургиулаад тэгэхийг зөвшөөрнө гэж даан ч байхгүй. Хэрэв газопроводыг хаах санаатай бол

²² Путин поговорит с Лукашенко о транзите газа в Европу, *Интернет-портал «Российской газеты»*, 13.11.2021

²³ Угрозы Лукашенко в адрес Европы оказались опасны для России, *twnews.nl/ru-news/11/11/2021*

Беларусь Оросоос бүр авах хэрэгтэй гэв. «Ямал–Европа» хоолой нутаг дээгүүрээ дамжуулснаас Беларусьт “Газпром” 5 тэрбум ам.доллар төлдөг, харин гэрээнд заахдаа тус улс хоолойг өөрийн болгох, эзэн мэдэх эрхгүй, хэрэв тэгэхийг завдвал нөгөө 5 тэрбумаа буцааж өгөх болно, бас дээр нь актив болгож байршуулсан 2 тэрбум нэмэгдэнэ, хэрэв Беларусь “Газпром”-оос хоолойг авахыг хүсвэл нийт 7 тэрбум ам.доллар Орост буцааж төлнө. Ийм будлианд Орос орохыг хүсэхгүй, Беларусиаас болж Европтой муудалцах яг үнэндээ сонирхолгүй хэмээн Үндэсний эрчим хүчний аюулгүй байдлын фондын сайтад бичсэн байх аж.

Хэрэв Лукашенко муйхарлавал Европын Холбоонд хий нийлүүлэгчдийн өөр нөөц бий, тэр нь Африкийн зарим улс, Норвег, мөн Орос байна хэмээн Европын Холбооны эдийн засгийн комиссар Паоло Жентилони ярьжээ²⁴.

Дээрхээс үзвэл Беларусийн лидер Европ руу чиглүүлсэн хэд хэдэн зэвсэг агсчээ.

Долоо. Төгсгөх логик үгс

Тэсрэлт хэмээн гарчигт өгүүлснээ дор тайлбарлана. Үнэхээр 2020-2021 он А.Лукашенкогийн хувьд эгэлгүй, адармаатай он жилүүд боллоо. Тэрээр тэсэхгүй тэсэрлээ. Эх орных нь тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал түүний дэглэмийн барьцаанд орлоо. Түрэмгий авир, байнгын заналхийллээрээ Европтоо бас нэг Ким Чен Ун болчихлоо гэдгийг Орос анд нөхөд нь элэглээд егөөдөөд дэлхийд зарлаад гаргаад ирлээ. Түүний тоглолт тасралтгүй

Дүрвэгсдийн цувааг хянахгүй (1), наркотрафикт хяналт тавихгүй (2), гурав дахь нь хэрэглээнийх нь хийн «Ямал–Европа» хоолойг боймлох (3). “Бид Европыг дулаацуулж байна, гэтэл тэд биднийг заналхийлнэ, хилээ хаана. Тэгвэл бид тийшээ явдаг байгалийн хийг нь хаачихъя л даа.Тийм учраас би Польшийн удирдлагад, литвачуудад зөвлөчихөө л дөө, юун тухай ярьж байгаагаа” –Лукашенкогийн цогтой үгс.

Лукашенког цогтой үгс зоригтой хэлүүлээд байдаг механизм гэж бас байна. Беларусь–Оросын «Холбооны Парламентын Хурал» гэх хоёр улсын парламентчдын чуулга уулзалт. Минскэд Хурлын 61 дүгээр чуулган²⁵ хуралдаж байх үед Беларусь–Польш, Беларусь–Литвагийн хил дээр маш түвэгтэй нөхцөл байдал бүрдээд байв. Өөрсдөө санаачлаад Ойрхи Дорнодоос баахан цагаач дүрвэгсэд авчраад, өөрсдөө хил рүү авчраад бөөгнөрөл үүсгэчихсэн, гэтэл буруутан нь Өрнөд болж хувирав.

үргэлжлэх төлөвтэй. Буруутан ба зөвтөн тодроод авлаа. Үгэн бөмбөгөөр хатуухан шидэлцсэн мэдээллийн дайн руу шилжлээ.

Арабын орнуудаас мусульман дүрвэгсдийг цуглуулаад бидэнд өг гэж Өрнөдөөс Беларусьтай тохиролцоогүй байтал Өрнөд нь одоогоор буруутан болчихлоо. Путин ч өмнө нь иймэрхүү утгатай зүйл²⁶ ярьчихсан. Юу гэвэл Беларусь–Польшийн хил дээрх нөхцөл байдал цэрэг, эдийн засгийн хүчин зүйлээс улбаатай

²⁴ В ЕС заявили, что не позволят Лукашенко запугать себя угрозами перекрыть газ, *gazeta.ru*, 2021/11/11/

²⁵ Парламентское Собрание Союза Беларуси и РФ приняло заявление по ситуации на белорусско-польской границе, *dumatv.ru*, 2 декабря 2021

²⁶ Путин и Лукашенко обсудили ситуацию на белорусско-польской границе, *tass.ru/politika/30* Ноя, 2021

гэж. Цэрэг, эдийн засгийн хүчин зүйл гэсэн нь бүр ч ноцтой юм.

Беларусь–Оросын парламентчид цааш нь юу юу гэж ялласныг сонирхъя:–АНУ ба Европын Холбооны зүгээс хөгжиж буй орнуудын дотоод хэрэгт хөндлөнгөөс түрэмгийлэн оролцох бодлого явуулснаас болж дэгдсэн хямрал хэмээн хоёр улсын депутатууд үзжээ²⁷. НАТО-гийн цэрэг шууд оролцож олон улсын экспанс хийж, энхийн амьдрал, төрийн байгуулалтынх нь үндсийг нураасан улс орны иргэд дүрвэгсдийн ихэнх хэсгийг бүрдүүлж байна. Хүний эрх хамгаална, олон улсын эрх, гуманизмын зарчим хэрэглэнэ гэж ярьдаг ч миграцын хямрал зохицуулахаар Беларусьтай ажил хэрэгчээр харилцан ажиллахгүй байгаа Европын Холбооны хоёрдмол стандар хуучирчээ. Үүн дээр Өрнөдийн орнууд төрийн хариуцлагагүй бодлого явуулж, миграцын хямралыг дэвэргэж байна. Үүнд нь зохих хариуг нь өгөх болно. Дүрвэгсдийн эрхийн талаар олон улсын амлалт үүргээ Европын ба Америкийн тал биелүүлэхийг шаардаж байна, Европын Зөвлөлийн Парламентын Ассамблей, ЕАБХАБ-ын Парламентын Ассамблей, Европын парламент, Европын Холбооны бусад байгууллагуудад хандан уриалж байна²⁸ гэхчлэн сүрлэг мэдэгдэл хийжээ.

Төгсгөх үг гэдэгт дараах мөрүүд зориулагдана. Аль аль талынх нь үзэж байгаагаар хоёр талаасаа л гибрид дайн хийж

байна. Беларусийн эсрэг бүх чиглэлээр Өрнөд гибрид дайн өдөөсөн хэмээн Лукашенко урсгана²⁹. Болохгүй бүтэхгүй бүхэн нь Европын Холбооноос тус орны эсрэг явуулж буй ер бусын дайн байх аж. Дүрвэгсдийн хямрал буюу Беларусьт хашигдсан үй түмэн лалын дүрвэгсэд бол түүний сонгодог жишээ нь гэнэ³⁰.

Харин амьд хүмүүсээр (цагаач дүрвэгсэд) зэвсэг хийн Европын Холбооны эсрэг гибрид дайн явуулсан гэх ял зэм анхлан Литвагаас цууриатсан. Түүнийг нь Брюссельд уухайлан дэмжиж Лукашенкогийн дэглэмийн эсрэг шинэ хориг тавихаар болсон. Польшид ч Лукашенкогийн гибрид дайны тухай багагүй шуугисан. Литва, Латви, Польш гурав нийлж аваад Лукашенкогийн гибрид дайны эсрэг хил хязгаараа бэхжүүлэх, цэрэгжүүлэх алхам хэрэгжүүлсэн³¹.

Их Британийн батлан хамгаалах штабын дарга генерал сэр Ник Картерын хэлсэн үгээр³² судалгааны өгүүллээ төгсгөө. Түүнийг дүгнэлт хэмээн хүлээн аваарай. “Хүйтэн дайн” дууссанаас хойш хамгийн түгшүүртэй үедээ Өрнөд ба Оросын харилцаа орчихоод байна. Санамсаргүй үйлдлээс дайн дэгдэхээр байна. Беларусиаас Польштой залгаа хил дээрээ цагаач дүрвэгсдийн хямрал дэгдээсэн нь Өрнөдийг нэн ихээр түгшээх шалтаг боллоо. Орос нь зорилгодоо хүрэхийн тулд элдэв зэвсэг хэрэгсэл ашиглаж байгаа боловч жинхэнэ дайн дэгдээхийг хүсэхгүй. Янз бүрийн глобал

²⁷ Парламентское Собрание Союза Беларуси и РФ приняло заявление по ситуации на белорусско-польской границе, *dumatv.ru*, 2 декабря 2021

²⁸ Мөн тэнд

²⁹ Лукашенко: против Беларуси развернута гибридная война практически по всем направлениям, *belta.by*, 29 ноября 2021

³⁰ Meeting with refugees in logistics hub near Bruzgi checkpoint, *president.gov.by*, November 26, 2021

³¹ Is the Belarus migrant crisis a ‘new type of war’? A conflict expert explains, *theconversation.com*, November 17, 2021

³² ‘Great risk’ of accidental war with Russia, says British top military official -‘Tensions’, *express.co.uk/world/ Sat*, Nov 13, 2021

стратеги ашиглан, байлдахгүйгээр хамгийн эгзэгтэй арга барилаар хүссэнээ олж авахыг Кремль санаархаж байна гэжээ.

Дайн дэгдээхгүйгээр ашиглаж буй тэрхүү зэвсэг, эгзэгтэй арга барил нь Беларусь болчихоод байгаа бус уу?

Accepted Manuscript

Эх сурвалж:

1. Совместное заседание глав государств – членов ШОС и ОДКБ, *kremlin.ru*, 17 сентября 2021 года
2. Парламентское Собрание Союза Беларуси и РФ приняло заявление по ситуации на белорусско-польской границе, *dumatv.ru*, 2 декабря 2021
3. H.R.8438 - Belarus Democracy, Human Rights, and Sovereignty Act of 2020 116th Congress (2019-2020), *congress.gov*
4. Путин поговорит с Лукашенко о транзите газа в Европу, *Интернет-портал «Российской газеты»*, 13.11.2021
5. Путин и Лукашенко обсудили ситуацию на белорусско-польской границе, *tass.ru/politika/30* Ноя, 2021
6. Путин прокомментировал ситуацию с перевозкой мигрантов в Белоруссии, *lenta.ru/2021/11/13/migrants/*
7. Александр Лукашенко: Мы все понимали, что Крым де-факто это российский Крым. После референдума и де-юре Крым стал российским, *forbes.ru/society/30.10.2021*
8. Лукашенко принимает участие в саммите ШОС. Какие интересы у Беларуси в этой организации? *belarus.by*, 17 сентября 2021 г.
9. Лукашенко: наступает время исторического стресс-теста для ШОС, мөн тэр сайтын мэдээ
10. Лукашенко: ОДКБ выступает гарантом и донором безопасности на Евразийском континенте, *belarus.by*, 16 сентября 2021 г.
11. Президент Лукашенко: среди организаторов доставки мигрантов к границе были и россияне, *ria.ru/2021/12/01/*
12. Лукашенко: против Беларуси развернута гибридная война практически по всем направлениям, *belta.by*, 29 Ноября 2021
13. Belarus President Alexander Lukashenko derides reports of abuse as 'fake and fantasy', *edition.cnn.com*, 2021/09/30/
14. Шушкевич заявил, что за 30 лет Белоруссия потеряла независимость, *gazeta.ru/politics/2021/08/25*
15. Тихановская призвала инициировать в Совбезе ООН слушания по Белоруссии, *rusckienovosti.ru/2021/04/08/*
16. Угрозы Лукашенко в адрес Европы оказались опасны для России, *twnews.nl/ru-news/11/11/2021*
17. В ЕС заявили, что не позволят Лукашенко запугать себя угрозами перекрыть газ, *gazeta.ru*, 2021/11/11/
18. «Молодежь нацелена в Европу» Белорусы вслед за украинцами стремятся в ЕС. Как Россия может их удержать? *yandex.ua/news/25* октября 2021
19. Беларусь планирует закупку российского вооружения более чем на \$1 млрд, *belta.by/president/12* Сентября 2021
20. Экономист Корнев сравнил угрозы Лукашенко перекрыть газопровод с политикой Ким Чен Ына, *actualnews.org/exclusive/* 11 ноября 2021
21. BelarusToday is on Facebook: Беларусь ради своего блага должна получить статус союзника США
22. На Украине заявили о «спланированной операции» России и Белоруссии, *imag.one*, 12.11.2021
23. Is the Belarus migrant crisis a 'new type of war'? A conflict expert explains, *theconversation.com*, November 17, 2021
24. Isolation Pushes Belarus's Lukashenko Closer to Russia's Putin, *The Wall Street Journal*, May 28, 2021
25. Belarus Focus of Central and East European Coalition Policy Discussion, *eancdc.wordpress.com*, March 5 2021
26. Poland Accuses Belarus of Terrorism at Border, *voanews.com*, November 10, 2021
27. U.S., Poland discuss Belarus migrants, Russian aggression –Blinken, *saltwire.com*, Reuters Nov.14, 2021,
28. Meeting with refugees in logistics hub near Bruzgi checkpoint, *president.gov.by*, November 26, 2021
29. 'Great risk' of accidental war with Russia, says British top military official -'Tensions', *express.co.uk/world/* Sat, Nov 13, 2021